

## Суралцахуйн шинэчлэлийг судлах асуудалд

С.Энхтүвшин (МУБИС, БСС,БСАЗТ)

### Хураангуй

Энэхүү өгүүлэлд 21-р зууны нийгэм, ажлын байрны шаардлагатай уялдан судлах үндсэн хичээлүүдийн бүтэц, сэдэв, эзэмших ур чадварын бүтэцчилсэн хүрээ, суралцахуйн үнэлгээний шинэчлэлийн асуудлыг судалсан бусад орны судлаачдын бүтээлд хийсэн агуулгын анализын үр дүнгээс танилцуулж, төсөлд тулгуурлан суралцах замаар суралцагчдын сурахуйд суралцах чадварыг хөгжүүлэх боломжийг авч үзэх болно.

**Түлхүүр үг:** үндсэн хичээлүүд (core subjects), 21-р зууны шинэ чадварууд (21<sup>st</sup> century skills), уян чадварууд (soft skills), суралцах үйл явцын өөрийн удирдлага (self-direction), өөрийн зохицуулалт (self-regulation), төсөлд тулгуурлан суралцахуй (project based learning), суралцахуйн явцын үнэлгээ (formative assessment), суралцагчийн өөрийн үнэлгээ (student self-assessment).

21-р зууны босгон дээр улс орон бүр иргэдийнхээ боловсрол эзэмших хэрэгцээ шаардлага, боловсролын агуулга, ялангуяа суурь боловсролын агуулга арга зүйд шүүмжлэлтэй хандаж шинээр тодорхойлох болсон нь хүн төрөлхтөн үйлдвэрлэлийн нийгмээс мэдээлэлжсэн нийгэмд шилжиж, түүнээс үүдэлтэй өөрчлөлт, даяаршил хурдацтай явагдаж байгаатай холбоотой. Энэхүү мэдлэгт суурилсан эдийн засаг бүхий нийгэмд амьдрах иргэд ямар ямар ур чадварыг зайлшгүй эзэмших шаардлагатай байгааг хөгжингүй орнуудын боловсрол судлаач эрдэмтэд 2000 оноос судалж, судалгааны үр дүнгээ олон нийттэй хуваалцан, сургалтын практикт хэрэглэж, үр шимийг нь хүртэж эхлээд байна. Тухайлбал, “21-р зууны ур чадварын төлөө түншлэл” (The Partnership for 21-st Century Skills) хэмээх АНУ-ын бизнес болон боловсролын байгууллагууд, олон нийтийн төлөөллийн оролцоотой зөвлөлөөс 2002-2006 онд үндэсний хэмжээний хэлэлцүүлэг зохион байгуулж, 21-р зуунд ажиллаж, амьдрахад шаардагдах чадваруудын бүтэцчилсэн хүрээг тогтоосон бол Английн судлаачдын баг 2020 он гэхэд багшлахуй ба суралцахуйн чиг хандлага ямар байхыг шинжлэн судалж, 2006 онд судалгааны үр дүнгээ олон нийтэд танилцуулсан илтгэлдээ мэдлэгт суурилсан эдийн засаг нь 21-р зуунд ажиллаж, амьдрах хүмүүсээс шинжлэх ухааны мэдлэгээс гадна уян чадваруудыг (soft skills) эзэмшихийг шаардах болсныг онцлон тэмдэглэжээ. Энэ мэтчилэн улс орон бүр шинэ зууны иргэдийн зайлшгүй эзэмшсэн байх мэдлэг, ур чадварыг өөрөөр авч үзэх болсон нь судлах зүйл, суралцах арга зам, сурах хөдөлмөрт хандах хандлага, суралцахуйн үр дүн болон үйл явцыг үнэлэх арга хэлбэрийг шинэчлэх асуудлыг ч дэвшүүлж байна.

### Судалгааны үр дүнгээс:

Хүмүүсийг ажиллаж, амьдрах арга замаа өөрчлөхөд эдийн засаг, технологи, мэдээлэл, хүн ам зүй, улс төрийн хүчин нөлөөлж байгаа билээ. Энэхүү өөрчлөлтийн хурд улам бүр нэмэгдэж байна. 21-р зууны суралцагчдад тавьж буй шаардлага, тэдний суралцах арга зам, хандлагад гарч буй өөрчлөлт нь өнгөрсөн зууны сүүл үеэс эхэлсэн эдийн засаг, ажил эрхлэлт, бизнес, үйлдвэрлэлийн суурь өөрчлөлтөөс үүдэлтэй. Сүүлийн 20-30 жилд үйлдвэрлэлийн эдийн засаг нь мэдээлэл, мэдлэг, шинэчлэлд суурилсан үйлчилгээний эдийн засагт байр сууриа тавьж өгөх үйл явц тасралтгүй явагдаж байна. АНУ-ын судлаач Алвин Тофлер энэ шилжилтийг 1980-аад оноос эхэлсэн гэж үзээд, хүн төрөлхтний туулж өнгөрүүлсэн нийгмийн

хувьсал өөрчлөлтийн гурав дахь давалгаа<sup>1</sup> гэж нэрлэсэн нь ч буй. Эл үйл явц олон улс оронд ажлын байрны чиг хандлага, улмаар ажил эрхлэлтийн бүтэц өөрчлөгдөхөд хүргэсэн билээ. Жишээ нь , АНУ-д 1995-2005 онд 3 сая хүн материаллаг үйлдвэрлэлийн салбараас гарсан бол мөн хугацаанд 17 сая хүн үйлчилгээний салбарт ажил эрхлэхээр орсон<sup>2</sup> байна. 2008 оны байдлаар АНУ-ын мэдээлэл, үйлчилгээний салбарт ажиллагсдын цалингийн орлого материаллаг үйлдвэрлэлийн салбарт ажиллагсдынхаас 20 000 америк доллараар их<sup>3</sup> байгааг тус улсын хөдөлмөр эрхлэлтийн статистикийн мэдээнд дурджээ.

Технологийн огцом өөрчлөлт нь ажлын байрны болон нийгмийн шаардлага, түүний практик үйл ажиллагааг эрс шинэчлэхэд хүргэсэн. Тавин жилийн өмнө үйлдвэр, албан байгууллагын ажилтан, ажилчид өдөр бүр ижил төрлийн ажил төрөл гүйцэтгэж, нэг янзын машин техник дээр олон жил ажиллаж байв. Технологийг хялбарчилж, олон дахин давтан хийдэг үйлдлүүдийг багасгасан явдал нь ур чадвар бага шаардах ажлын байрыг хорогдуулж, өндөр ур чадвартай ажилчдын ажил эрхлэх, ажлын хөлсөө нэмэгдүүлэх боломжийг мөн тийм хэмжээгээр нэмэгдүүлсэн аж. Өнөөдөр аливаа үйлдвэр, албан байгууллагын ажилтнууд зах зээлийн эрэлтэд зохицон байнга хувьсан өөрчлөгдөж буй ажлын байранд өндөр зэрэглэлийн машин техник, цахим тоног төхөөрөмжийг ашиглан, олон төрлийн ажил, үүргийг гүйцэтгэж байна.

Иймд өнөөдрийн бизнес эрхлэгчид, ажил олгогчид өөрчлөлтийн хэрэгцээнд дасан зохицож чадах, олон ажлыг амжуулж, олон талын хариуцлага хүлээн, шийдвэр гаргаж чадах нэгнийг л хайж байна. Өөрөөр хэлбэл, өнөөдрийн эдийн засаг нь “ Өргөн хүрээтэй мэдлэг, олон талын чадвар, уян хатан чанар хийгээд сургалтын хүрээнд хязгаарлагдаагүй, олон зорилтыг агуулсан, багаар ажиллаж, асуудал шийдвэрлэхийг шаардсан, төсөлд тулгуурласан ажлыг үнэ цэнэтэй болгож байна”<sup>4</sup>. Хүний нөөцийн мэргэжилтэн Алан Грийнспаны хэлснээр, эдийн засаг дахь 21-р зууны ур чадварын хэрэгцээ нь “Олон мэргэжлийн ажилчдын хувьд зөвхөн танин мэдэх чадвараа хөгжүүлэх, мэргэжлийн үнэмлэхтэй болох нь хангалттай бус, харин ажлыг хэрхэн хийхээ мэдээд зогсохгүй, мэдээллийг хувирган өөрчлөх, дүн шинжилгээ хийх, бас шинээр бүтээх, бусадтай үр дүнтэй харилцаж чаддаг байх шаардлагатай болжээ. Цаашдаа суралцахуй нь хүний насан туршийн үйл ажиллагаа болж байна”<sup>5</sup>. Хүүхдүүдийн амьдарч буй ертөнц ийнхүү эрс өөрчлөгдөж байхад сургууль ч бас бизнесийн байгууллага, нийгэм, гэр бүлийн нэгэн адил энэхүү өөрчлөлтөд дасан зохицож, үйлдвэрлэлийн нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангаж байсан өмнөх үеийн үйл ажиллагааны арга барилаа үндсээр нь шинэчилж, өөрчлөх шаардлагатай байна.

Ийнхүү 21-р зуунд ажиллаж, амьдрах иргэд ажлын байрны шаардлагаар мэдлэг, ур чадвараа шинэчлэх, өөрчлөхөд бэлэн, илүү уян хатан байх, насан туршдаа суралцаж, өөрийгөө хөгжүүлж чаддаг байх нь шинэ зууны эдийн засгийн нэгэн гол тулгуур хүчин зүйл болжээ. Америкийн судлаач Мое, Бюджет нар хүмүүсийн эзэмшсэн мэдлэг, чадвар, эдийн засгийн шинэчлэлийн хамаарлыг судалсан бүтээлдээ, ажлын хийж гүйцэтгэх хүрээ явцуу болох тусам мэргэжлийн ур чадвар нь хоцрогдох, хуучрах магадлал төдий чинээ нэмэгддэг болохыг дурдаад, өнөө үеийн ихэнх ажилтнуудын сурч эзэмшсэн зүйл гурваас таван жилийн

<sup>1</sup> Alvin Toffler, Third Wave, New York, 2001

<sup>2</sup> Research at the UCLA Anderson School of Management (Karmarkar & Apte, 2007; Apte, Karmarkar & Nath, 2008) documents the rise of the service economy

<sup>3</sup> Karmarkar & Apte, 2007; Apte, Karmarkar & Nath, 2008

<sup>4</sup> National Skill Standards Board, Using Skill Standards and Certification in Workforce Investment Board Programs, 2002

<sup>5</sup> “The Evolving Demand for Skills” remarks by Alan Greenspan at the U.S Department of Labor National Skills Summit, April 11, 2000

дараа шаардлага хангахгүй болно<sup>6</sup> гэдгийг анхааруулсан байдаг. Иймд ямар ч төрлийн ажил эрхэлж буй хүн насан туршийн суралцагч байх, мэдлэг, ур чадвараа тасралтгүй, бие даан дээшлүүлж чаддаг байх хэрэгтэй болж байна.

Нөгөө талаар, технологи, мэдээлэл харилцааны хөгжил нь дэлхий ертэнцийг нэгэн глобал нийгэм (global community) болгон хувиргаснаар газар нутгийн орон зайгаар үл хязгаарлагдах бизнесийн шинэ түнш, өрсөлдөгчдийг буй болгож байна. Энэ нь олон хэл, соёлын орчинд амьдрах чадвар, өөр соёлыг ойлгох, ойлголцох чадварыг ч бас шаардаж байгаа юм.

Эдийн засаг, ажил эрхлэлт, бизнесийн энэхүү суурь өөрчлөлт нь 21-р зууны иргэдийн шинэ мэдлэг, чадвар эзэмшихийг шаардаж байгаа учраас олон улс оронд боловсролын судалгааны байгууллагууд, бизнес эрхлэгчид, ажил олгогчидтой хамтран ажиллаж, шинэ зууны иргэдийн судлах үндсэн хичээлүүд (key subjects), заавал эзэмших чадварын бүтэцчилсэн хүрээг судалж, үр дүнгээ олон нийтэд танилцуулж, хэлэлцүүлэн, сургалтын практикт хэрэглэж байна.

Академик хичээлүүдийг судлах замаар боловсрол эзэмших санаа зуугаад жилийн түүхтэй ч өнөөдөр ач холбогдлоо алдаагүй л байна. Гэхдээ энэхүү үндсэн хичээлүүдийн бүтэц ихээхэн өөрчлөгджээ. 2000 оныг хүртэл Англи хэл, математик, шинжлэх ухааны хичээлүүд (байгалийн ухааны), нийгэм судлал зэрэг нь дунд сургуулийн сурагч бүрийн заавал судлах үндсэн хичээлүүд байсан бол 2001 оноос эхлэн эл бүтэц өргөжиж, Англи хэл(төрөлх хэл), унших, математик, шинжлэх ухааны хичээл, гадаад хэл, иргэншил, засаглал, эдийн засаг, урлаг, түүх, газарзүй<sup>7</sup> гэх зэрэг хичээлүүдээс бүрдэх болжээ. 21-р зууны босгон дээр боловсруулсан “Нэг ч хүүхэд хоцрох ёсгүй” хэмээх баримт бичиг, судлах үндсэн хичээлийн тоо ийнхүү нэмэгдсэн шалтгааныг 21-р зууны ажлын байр, нийгмийн зүгээс тавьж буй шаардлагатай холбон тайлбарлажээ. Тухайлбал, даяаршил, дэлхийн эдийн засаг зэрэгтэй холбогдон, гадаад хэл, эдийн засаг, газарзүйн хичээлийг судлах шаардлагатай болж байгаа аж.

Үүнтэй холбоотой 21-р зууны даяарчилагдсан нийгэм, ажлын байр, амьдралын хэв шинжийг тусгасан шинэ агуулгын тухай асуудлыг ч хөндөх боллоо. Иймд 21-р зууны сургалтын **үндсэн сэдвүүд ( 21<sup>st</sup> Century Themes)**-д дараах асуудлыг тусгах болж байна.

1. Глобал ойлголтууд. Даяаршил, технологийн дэвшил нь газарзүйн хил хязгаар, цагийн зөрөөг үгүй болгож, харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж буй эл цаг үед хүмүүс олон соёлын орчинд ажиллаж, амьдрах хэрэгтэй болж байна. Глобал ойлголтууд нь бусад үндэсний соёл, шашны ялгааг ойлгох, хүлээцтэй хандаж сурахад туслаад зогсохгүй асуудлыг олон талаас нь, шүүмжлэлтэй харж сурах боломжийг ч олгодог.

2. Санхүү, эдийн засаг, бизнесийн асуудал. Хүмүүс хувийн амьдралдаа ч, эрхэлж буй ажил дээрээ ч алхам тутамдаа эдийн засгийн болон бизнесийн сонголт хийдэг, энэ нь ирээдүйн ажил, амьдралд нь янз бүрээр нөлөөлдөг нь нууц биш”. Коллежийн диплом миний орлогыг нэмэгдүүлэх үү?”, “Машин худалдан авах нь ухаалаг шийдвэр мөн үү?”, “Тэтгэврийн хуримтлалыг яагаад одооноос хийх ёстой вэ?” гэх мэтийн өдөр тутмын сонголт нь хувь хүний амьдралыг дэвшилд эсвэл доройтолд хүргэдэг байтал ихэнх хүмүүс дунд сургуульд байхдаа энэ сэдвэр ярилцаж байсан нь чамлалттай байдаг аж. Санхүүгийн мэдлэггүй олон хүний өөрсдийнхөө болон гэр бүлийнхээ төлөө гаргасан ухаалаг бус шийдвэрүүд нэгдэн нийлсээр

---

<sup>6</sup> Moe, M.T. and Blodget, H. The Knowledge Web: People Power- Fuel for the New Economy 2000.

<sup>7</sup> No child Left Behind, Title IX- General Provisions, Part A- Definitions

эцсийн дүндээ үндэсний хэмжээнд сөрөг үр дагавар учруулж болзошгүй байгааг<sup>8</sup> судлаачид анхааруулсан байдаг. Үүний нэгэн адил ажлын байран дээр ч бизнесийн үйл явцыг ухаарч ойлгосон шийдвэр гаргах хэрэгтэй болдог. Жишээ нь, “Миний хийж гүйцэтгэх зүйл манай компаний амжилтад хэрхэн нөлөөлөх вэ?”, “Би байгууллагынхаа зорилгод ямар дэмжлэг үзүүлж, ямар хувь нэмэр оруулж чадах вэ?”, “Энэ төслийн санал бизнесийн аятай боломж олгож буй эсэхийг би үнэлж чадаж байна уу?”, “Энэ хүн манай багт тохирох уу?” гэх зэрэг асуултад оновчтой хариулт өгч чаддаг байх нь ажлын байрны бүтээмжид ч бас нөлөөлнө. Мөн зарим улс орон бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн асуудлыг нарийвчлан судлах болж байна.

**3. Иргэний боловсролын асуудал.** Улс төрийн болон нийгмийн хүрээний бүхий л амьдралд мэдээлэлтэй, хариуцлагатай оролцдог иргэд хэрэгтэй байна. Иргэний боловсрол нь суралцагчдад засаглалыг ойлгож, дүн шинжилгээ хийж, зөв сонголт хийж сурахад нь туслах болно. Дээрх сэдвийг шинэ курс хичээл болгож үзэх бус, өмнө өгүүлсэн үндсэн хичээлүүдийн агуулгад нэмж суулгах байдлаар судалж байна.

21-р зууны шаардлагыг хангахын тулд тулд хүмүүс дээр дурдсан үндсэн хичээлүүдээс гадна өөр олон зүйлийг мэдэх хэрэгтэй болж байна. Юуны өмнө тэд мэдлэг, ур чадвараа хэрхэн ашиглахаа мэддэг байх, тухайлбал, шүүмжлэлтэйгээр сэтгэх, шинэ нөхцөлд мэдлэгээ хэрэглэх, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, шинэ санааг ойлгох, харилцах, хамтран ажиллах, асуудлыг шийдвэрлэх, шийдвэр гаргахад ашиглаж чаддаг байх хэрэгтэй байна. Иймд дээрх үндсэн хичээлүүдээс гадна, шинэ зууны иргэдийн заавал эзэмших чадварын бүтэцчилсэн хүрээг судалж тогтоох явдал нь боловсролын судалгааны байгууллагуудын анхаарлын төвд байсаар байна. Үүнд бизнес эрхлэгчид, ажил олгогчид, багш нарын мэргэжлийн холбоод, олон нийтийн төлөө идэвхтэй, хариуцлагатай оролцох болжээ. Тухайлбал, АНУ-ын боловсрол судлаачид, ажил олгогчдын хамтарсан комиссоос **21-р зууны ажлын байр дараах чадварыг заавал эзэмшихийг шаардаж байгаа**<sup>9</sup>-г тогтоосон байна. Үүнд:

- Нөөцийг (цаг хугацаа, материал, хүн хүч) хуваарилах, төлөвлөх, зохион байгуулах
- Бусад хүмүүстэй харилцах, хамтран ажиллах
- Мэдээлэлтэй ажиллах
- Тогтолцоонд нь ойлгох, боловсруулах, боловсронгуй болгох
- Технологийг хэрэглэх

Дээрх үндсэн чанараас гадна суралцах, бүтээлчээр сэтгэх, шийдвэр гаргах чадвар болон хувийн хариуцлагатай байх, өөрийгөө хүндэтгэх, өөрийгөө удирдах, нийтэч, зарчимч байх зэрэг бие хүний эрхэм чанаруудыг бас хөгжүүлэх шаардлагатай<sup>10</sup> байгааг дурджээ.

Мөн **2020 оны багшлахуйн ба суралцахуйн чиг хандлагыг** тандан судалсан Английн судлаачдын баг мэдлэгт суурилсан эдийн засаг бүхий технологижсон нийгэмд амьдрахад дараах **уян чадвар (soft skills)**-уудыг эзэмших шаардлагатай байгаа<sup>11</sup>-г тогтоожээ. Үүнд:

<sup>8</sup> “Financial Literacy in America: Individual Choices, National Consequences.” A white paper from National Endowment for Financial Education Symposium, October 2002

<sup>9</sup> The Report, What Work Requires of Schools, the U.S. Secretary of Labor’s Commission on Achieving Necessary Skills (SCANS), 1991, Washington, DC

<sup>10</sup> Мөн тэнд

<sup>11</sup> A vision for Teaching and Learning in 2020, Review Group, 2006, Department for Education and Skills, UK, p.10

- Ам, бичгээр өндөр түвшинд харилцах
- Ажлыг цаг хугацаанд нь, найдвартай хийж гүйцэтгэх, шургуу, цөхрөлтгүй ажиллах
- Багт ажиллах
- Мэдээлэлд шүүмжлэлтэй хандаж, үнэлэх
- Хариуцлага хүлээх, суралцах үйл явцаа удирдах, сурах эерэг хэвшлээ бататгах
- Бие даан ажиллах
- Өөртөө итгэх, асуудлыг шинжилж, шийдлийг олох
- Асуудлыг олон талаас нь харах, ажил үүргээ өргөн хүрээнд гүйцэтгэх
- Бэрхшээлийг даван туулах
- Шинэ нөхцөлд хурдан дасан зохицох, уян хатан байх
- Шинийг сэдэх, бүтээлчээр сэтгэх
- Бизнес сэтгэлгээ хөгжүүлэх, санаачлах

21-р зуунд ажиллаж, амьдрах иргэдийн эзэмших шаардлагатай эдгээр чадвар нь улс орнуудын үндэсний баялгийг нэмэгдүүлэх нэг гол хүчин зүйл болж байгааг нэртэй эдийн засагчид (М.Е. Портер, К.Кетэлс) нэг бус удаа тэмдэглэсэн байдаг. Дэлхийн Эдийн Засгийн Форумын 2007-2008 оны илтгэлд, “Хүчирхэг эдийн засагтай улс орнууд зах зээл дээр хамгийн сүүлийн үеийн арга техникийг ашиглан, глобал технологит тулгуурлан шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэж, шинэ төрлийн үйлчилгээ үзүүлэх замаар өөр хоорондоо өрсөлдөж байна. Өндөр ашиг орлоготой улс орнууд нь шинэчлэл хийх асар их чадавхи, нөөцтэй байна. Тэд соёлын ялгаанд туйлын мэдрэмжтэй ханддаг, шинэ санаа, өөр санаа бодолд нээлттэй байж, өөрчлөлтөд дасан зохицож чаддагаараа бусдаас ялгарч байна”<sup>12</sup> хэмээн онцлон тэмдэглэжээ. Ийнхүү шинэ санаа гаргах, шинийг сэдэх, бүтээхийн үндэс нь шинэ зүйлд тасралтгүй суралцах явдал болж байна. Үүний тулд сурахуйд суралцах чадварыг ямар ч ажил алба эрхэлж буй хүн бүр эзэмших шаардлагатай болжээ.

21-р зууны ур чадварын төлөө түншлэлээс (боловсрол судлаачид, бизнес эрхлэгч, ажил олгогчид, олон нийтийн төлөөллийн) сурахуйд суралцах чадвар (learning to learn skills)-ыг дараах гурван хүрээнд тодорхойлсон байна. Үүнд:

1. Мэдээлэл, харилцааны чадвар (Information and communication skills)
2. Шүүмжлэлтэйгээр сэтгэх ба асуудал шийдвэрлэх чадвар (Critical thinking and problem-solving skills)
3. Хүмүүс хоорондын харилцааны ба өөрийгөө удирдах чадвар ( Interpersonal and self-directional skills)


Энэхүү суралцах чадварыг эзэмших үндэс нь суралцагчийн өөрийн удирдлага-зохицуулалт бүхий үйл ажиллагаа аж.

АНУ-ын Станфордын их сургуулийн судлагч Эрик Ханушек нарын 2008 онд хийсэн судалгаа, PISA (Program for International Student Assessment)-ийн судалгаанд сурагчид нь өндөр оноо авч байсан улс орнуудын дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ)-ий өсөлт өндөр түвшинд байгааг тогтоожээ. Уг судалгааны тайланд эдийн засгийн хөгжлөөрөө тэргүүлж буй улс орнууд танин мэдэх чадварын түвшнээрээ 1960-2000 онуудад судалгаанд хамрагдсан 50 орноос илт ялгарч байсныг тэмдэглэсэн байна. Тэд цааш нь өндөр ур чадвартай ажиллах хүчин нь эдийн засгийн өсөлтийг жил тутам доод тал нь 2-3 хувиар нэмэгдүүлж чадаж байсныг дурджээ. Дэлхийн хэмжээнд ДНБ-ий өсөлт өмнөх 50 жилээс 2-3 хувь илүү өсч байсан нь ажил эрхлэгчдийн суралцах чадварын өсөлттэй холбоотой аж. Судалгааны үр дүнгээс үзвэл,

<sup>12</sup> Porter .Michael E., Ketels. Christian., & Delgado. Mercedes. (2007).” The Microeconomic Foundations of the Prosperity: Findings from the Business Competitiveness Index.” The Global Competitiveness Report 2007-2008. The World Economic Forum.

иргэдийн шүүмжлэлтэйгээр сэтгэх, асуудал шийдвэрлэх чадварын хөгжил нь улс орнуудын эдийн засгийн өсөлтийн ялгааг тайлбарлах нэг гол хүчин зүйл<sup>13</sup> болж байна.

PISA-ийн судалгаанд 2000 оноос хойш жил бүр тэргүүлэх байрыг эзэлсээр ирсэн Финляндын сурагчдын амжилтын нууцыг сонирхох, туршлагаас нь хуваалцахыг хүссэн судлаачдын тоо өсч байгаа билээ.



Финляндын Хелсинкийн их сургуулийн профессоруудын баг сурагчдынхаа амжилтын үндсийг багш боловсрол ба сургалтын хөтөлбөрийн шинэчлэл, өөрийн удирдлага зохицуулалт бүхий суралцахуй ( self-directed learning)-тай холбон тайлбарласан байдаг. Багшийн сурган хүмүүжүүлэх сэтгэлгээ, багшлах үйлийн эргэцүүлэлд суурилсан багш боловсролын шинэчлэл, сургалтын хөтөлбөрийн шинэчлэл нь улс төрийн тогтвортой орчинд, хувьсгалын бус хувьслын замаар явагдсаныг ч мөнөөх профессоруудын баг онцлон тэмдэглэжээ.

21-р зууны суралцахуйн шинэ чиг хандлага болох суралцах үйл явцын өөрийн удирдлага зохицуулалт нь Финляндын сургалтын практикт хэрэгжихэд скандиновын орнуудад дэлхийн хоёр дугаар дайны дараах үе, ялангуяа баруун европт 1960-аад оны үед өрнөсөн оюутны хөдөлгөөний үеэс боловсролыг ардчилах үйл явц, сургалтыг зохион байгуулах хэлбэр, арга замд гарсан хувьсал өөрчлөлтийн үр дүнд хөгжсөн төсөлд тулгуурлан суралцахуй (project based learning) ихээхэн нөлөөлсөн байна.

21-р зууны нийгэм, ажлын байрны шаардлагаар суралцагчдын эзэмших мэдлэг, ур чадвар, судлах сэдвийн хүрээ, агуулга ийнхүү өөрчлөгдсөнөөр уламжлалт стандартчилагдсан тестэд шүүмжлэлтэй хандах боллоо. Тухайлбал, стандартчилагдсан тестэд тулгуурласан үнэлгээний уламжлалт хэлбэрийг суралцагч мэдэж буй зүйлээ шинэ нөхцөлд хэрхэн хэрэглэж, асуудал

<sup>13</sup> Council on Competitiveness. (April 2008). Thrive. The Skills Imperative. Washington. DC: Author.

шийдвэрлэх болон бусадтай харилцахдаа мэдээллийн технологийг хэр зэрэг ашиглаж буйг хэмжиж чадахгүйн дээр багш нарт практик үйл ажиллагаагаа засан сайжруулахад нь хэрэг болох мэдээллээр хангах буцах холбоо болохгүй байгаа зэрэг үндэслэлээр шүүмжилж байна. Иймд суралцахуйн үр дүнгийн үнэлгээ (summative assessment)-нээс гадна явцын үнэлгээ (formative assessment), суралцагчийн өөрийн үнэлгээ (self student-assessment), үе тэнгийнхний үнэлгээ (peer evaluation)-г сургалтын практикт нэвтрүүлэх шаардлагатай боллоо. Мөн суралцагчийн шүүмжлэлтэйгээр сэтгэх, асуудлыг шинжлэх, мэдээлэл боловсруулах, мэдээлэлтэй, үндэслэлтэй шийдвэр гаргахын тулд мэдээллийн технологийг ашиглаж чадаж буй эсэхийг хэмжихийн тулд гүйцэтгэлд суурилсан үнэлгээний удирдамж (rubric) боловсруулж, үнэлгээнд хэрэглэхээс өмнө суралцагчид урьдчилан танилцах боломжоор хангах нь үнэлгээ сургалтын процессын нэг үндсэн хэсэг болох нөхцлийг бүрдүүлэх юм. Энэ боломжийг төсөлд тулгуурласан суралцахуй олгоно.

21-р зууны ажлын байрны шаардаж буй насан туршдаа суралцах чадварыг суралцагч суралцах үйл явцаа өөрөө удирдан зохион байгуулж, сурах хариуцлагыг өөрөө хүлээсэн үед л хөгждөг болох нь бидний туршилт судалгааны эхний үр дүнгээс харагдаж байна. 2008-2009 оны хичээлийн жилийн 1-р улиралд нийслэлийн Оюуны Ундраа цогцолбор сургуулийн 11-р ангийн 7-р бүлгийн сурагчдыг “БИД НЭГ ДЭЛХИЙТЭЙ” төсөл дээр ажиллах замаар тогтвортой хөгжлийн асуудлыг судлах туршилт судалгааны ажилд оролцуулсан юм. Энэхүү сургах туршилтаас төсөлд тулгуурлан суралцахуйн бүтцийн үндсэн элементүүд нь суралцагчдад суралцах үйл явцаа удирдан зохицуулах боломж олгодог болох нь илэрч байв. (Ажиглалтын үр дүнд хийсэн дүгнэлтэд үндэслэн боловсруулсан хүснэгтийг харна уу).

ТТС-н элементүүд	<u>Төслийн удиртгал</u> <i>(Юу мэддэг, чаддаг болох вэ?)</i>	<u>Төслийн даалгавар</u> <i>( Чиглүүлэх асуултууд)</i>	<u>Төслийн үйл явц алхмууд</u>	<u>Нөөц, хэрэглэгдэхүүн</u>	<u>Хамтын ажиллагаа</u> <i>(Төслийн багийн уулзалт, хэлэлцүүлэг, төслийн зөвлөхийн дэмжлэг)</i>	<u>ТҮА-ны эргэцүүлэл, үнэлгээ</u>
Суралцах үйл явцыг удирдан зохицуулахад үзүүлсэн нөлөө	Суралцах үйлийг санаачлахад  (Сурах хэрэгцээгээ олж харах зорилгоо тодорхойлох)	Судлах, шинжлэх, үйл ажиллагааны явцад суралцахад	Суралцах үйлээ төлөвлөхөд	Мэдээллийг үнэлэх, шүүмжлэлтэй хандахад, мэдээллийн технологийг хэрэглэхэд	Бусадтай харилцах хамтарч ажиллахад суралцах үйл ажиллагааны удирдамж, зөвлөмж ашиглаж сурахад, суралцах бэрхшээлийг даван туулахад хамтын хариуцлага хүлээж сурахад	Суралцах үйлээ үнэлж сурахад

## **Дүгнэлт:**

- 21-р зууны нийгэм, ажлын байрны шаардлагаар суралцагчдын эзэмших мэдлэг, ур чадварын бүтэцчилсэн хүрээ өөрчлөгдөж байгаатай холбогдон үндсэн хичээлүүдийн бүтэц, судлах сэдвүүд, эзэмших ур чадвар, үнэлгээний арга хэлбэрийг шинэчлэх шаардлагатай болж байна.
- Зах зээлийн эрэлтэд зохицон байнга хувьсан өөрчлөгдөж буй ажлын байранд олон төрлийн ажил үүргийг зэрэгцүүлэн гүйцэтгэж, ажиллаж, амьдрах иргэд мэдлэг, ур чадвараа байнга шинэчлэх, өөрчлөлтөд дасан зохицохын тулд насан туршдаа суралцаж чаддаг байх нь шинэ зууны эдийн засгийн нэгэн гол тулгуур хүчин зүйл болж байна.
- Насан туршдаа суралцахын тулд сурахуйд суралцах чадварыг эзэмших, суралцах үйл явцыг өөрөө хариуцаж, удирдан зохицуулж сурах хэрэгтэй байна.
- Төсөлд тулгуурлан суралцах замаар суралцагчдын өөрийн зохицуулалт-удирдлага бүхий үйл ажиллагааг дэмжин, сурахуйд суралцах чадварыг хөгжүүлэх боломж байна.
- Өөрийн зохицуулалт-удирдлага хөгжих нэг үндэс нь өөрийгөө үнэлэх чадвар мөн. Эл чадварыг хөгжүүлэхийн тулд суралцах үйл явцын эргэцүүлэлд тулгуурласан өөрийн үнэлгээг сургалтын практикт өргөн ашиглах хэрэгтэй.

## **Санал:**

- 21-р зууны монголын үндэсний үйлдвэр, аж ахуйн нэгж, албан байгууллагууд ажиллагсдаас ямар ур чадвар, бие хүний чанарыг шаардаж буйг тогтоох зорилгоор үндэсний бизнес эрхлэгчид, ажил олгогчид (хүний нөөцийн мэргэжилтнүүд), олон нийтийн төлөөлөл, боловсрол судлаач эрдэмтдийн цуврал уулзалт, хэлэлцүүлгүүдийг үндэсний хэмжээнд зохион байгуулах, үүнд олон улсын болон төрийн бус байгууллагуудыг өргөн оролцуулж, дэмжлэг туслалцаа авах
- Боловсролын стандартыг үнэлэх, үндэсний хэмжээнд мөрдөх сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явцад багш нарын мэргэжлийн холбоод, судалгааны байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх



### **Ашигласан материал:**

1. Alvin Toffler, *Third Wave*, New York, 2001
2. A vision for Teaching and Learning in 2020, Review Group, 2006, Department for Education and Skills, UK.
3. Council on Competitiveness. (April 2008). *Thrive. The Skills Imperative*. Washington. DC: Author
4. "Financial Literacy in America: Individual Choices, National Consequences." A white paper from National Endowment for Financial Education Symposium, October 2002.
5. Moe, M.T. and Blodget, H. *The Knowledge Web: People Power- Fuel for the New Economy* 2000.
6. National Skill Standards Board, *Using Skill Standards and Certifications in Workforce Investment Board Programs*, 2002.
7. No child Left Behind, Title IX- General Provisions, Part A- Definitions
8. Porter .Michael E., Ketels. Christian & Delgado. Mercedes. (2007). "The Microeconomic Foundations of the Prosperity: Findings from the Business Competitiveness Index." *The Global Competitiveness Report 2007-2008*. The World Economic Forum.
9. Research at the UCLA Anderson School of Management ( Karmarkar & Apte,2007; Apte, Karmarkar & Nath,2008) documents the rise of the service economy
10. The Report, *What Work Requires of Schools*, the U.S. Secretary of Labor`s Commission on Achieving Necessary Skills (SCANS),1991, Washington, DC.
11. "The Evolving Demand for Skills" remarks by Alan Greenspan at the U.S. Department of Labor National Skills Summit, April11, 2000.
12. Энхтүвшин С." Төсөлд тулгуурлан суралцахуй"-н туршилтын ажиглалтын тэмдэглэл, 2008-2009 оны хичээлийн жил,Оюуны Ундраа цогцолбор сургууль.